



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 04 сарын 11 өдөр

Дугаар А/146

Мандалговь

"Хүүхэд эрхэм хэрэглэгч" нөлөөллийн
аяныг зохион байгуулах тухай

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, 15.1.5, 18 дугаар зүйлийн 18.1.2, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, сангийн сайдын 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/23, 27 дугаар хамтарсан тушаалын 3 дугаар хавсралт, Төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн шууд захирагчтай байгуулсан 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд төр, хувийн хэвшлийн байгууллагууд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, хүүхдийг болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилготой "Хүүхэд эрхэм хэрэглэгч" нөлөөллийн аяныг 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс 04 дүгээр сарын 15-ны өдөр хүртэл зохион байгуулсугай.

2. "Хүүхэд эрхэм хэрэглэгч" нөлөөллийн аяныг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, үйл ажиллагааны удирдамжийг 2 дугаар, шаардагдах зардлыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Нөлөөллийн аяныг чанартай зохион байгуулж, хэрэгжилтийг хугацаанд нь тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Цэцэг), гишүүдэд үүрэг болгосугай.

4. Үйл ажиллагаанд шаардагдах 231,000 (Хоёр зуун гучин нэгэн мянга) төгрөгийг Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.

5. Үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Даргын дэргэдэх зөвлөлд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Цэцэг)-т даалгасугай.

ДАРГА

Ц.ГАНЗОРИГ

• 482201051

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,
залуучуудын хөгжлийн газрын даргын
2022 оны ~~11~~ дугаар сарын ~~11~~ ний өдрийн
~~11/11~~ дугаар тушаалын ~~11~~ дугаар хавсралт

**"ХҮҮХЭД ЭРХЭМ ХЭРЭГЛЭГЧ" НӨЛӨӨЛЛИЙН
АЯНЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Цэцэг

(Хүүхэд хамгааллын асуудал хариуцсан
Мэргэжилтэн)

Гишүүд:

Ш.Эрдэнэсүвд

(Хүүхэд хамгаалал, залуучуудын асуудал
хариуцсан мэргэжилтэн)

Л.Мөнхсарнай

(Хүүхдийн хөгжил, оролцоо хариуцсан
мэргэжилтэн)

Б.Бүжинлхам

(Гэр бүлийн асуудал хариуцсан
мэргэжилтэн)

Д.Мигар

(Хамгаалах байрны арга зүйч, сэтгэлзүйч)

•

---oOo---

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,
залуучуудын хөгжлийн газрын даргын
2022 оны 03 дугаар сарын 11 ний өдрийн
11/26 дугаар тушаалын 02 дугаар хавсралт

**"ХҮҮХЭД ЭРХЭМ ХЭРЭГЛЭГЧ" АЯНЫГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ**

Сургалтын зорилго: Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд төр, хувийн хэвшлийн байгууллагууд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, хүүхдийг болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэхэд оршино.

Хэзээ: 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс 04 дүгээр сарын 15-ны өдөр хүртэл зохион байгуулна.

Хамрах хүрээ:

0-18 насны хүүхэд

Эцэг эх, асран хамгаалагчид

Сургууль, цэцэрлэг, хүүхдийн хөгжлийн төв, хүүхдийн ордон

Хүнс барааны дэлгүүр, зах

Зохион байгуулагч: Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар

Хамтран зохион байгуулагч: Дундговь аймаг дахь Цагдаагийн газар, аймгийн хүүхдийн нэгдсэн зөвлөл

Зохион байгуулагдах үйл ажиллагаа:

№	Үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах албан тушаалтан
1	Хүүхдийн эрх, хамгааллын талаарх ойлголт өгөх агуулга бүхий постер, зөвлөмж хийж, түгээх	III/15-12	Мэргэжилтэн Б.Цэцэг
2	Хувийн хэвшлийн аж ахуй нэгж, байгууллага, худалдаа, үйлчилгээ эрхлэгч иргэдэд "Хүүхдийн эрх ба бизнесийн зарчим"-ыг сурталчилан таниулах уулзалт зохион байгуулах	XI/3-12	Мэргэжилтэн Ш.Эрдэнэсүвд
3	Байгууллагын эцэг, эхийн зөвлөлийн гишүүдийг хүүхдийг эрсдлээс хамгаалах нь сургалт зохион байгуулах	XI/1-5	Мэргэжилтэн Б.Бүжинлхам
4	Хүүхэд эрхэм хэрэглэгч аяны хүрээнд хүүхдийн эрүүл мэндийг дэмжих сэрэмжлүүлэг бэлдэх, цахим орчинд түгээх	XI/10	Мэргэжилтэн Ш.Эрдэнэсүвд х/ч Д.Цэвэлмаа
5	Нэг дүгээрт шалга арга хэмжээг сургууль, цэцэрлэг, олон нийтийн газруудаар зохион байгуулж, эрсдлийг арилгуулах	XI/2-12	Мэргэжилтэн Л.Мөнхсарнай АХНЗ

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,
залуучуудын хөгжлийн газрын даргын
2022 оны ~~01~~ дүгээр сарын ~~11~~ ний өдрийн
~~1116~~ дугаар тушаалын ~~01~~ дугаар хавсралт

“ХҮҮХЭД ЭРХЭМ ХЭРЭГЛЭГЧ” АЯНЫГ ЗОХИОН
БАЙГУУЛАХАД ШААРДАГДАХ ТӨСВИЙН ТООЦОО

№	Зардлын ангилал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Хэдэн удаа	Нийт үнэ
Цайны материал						
1	Печень	ш	42	2,000	1	84000
2	Кофе	ш	42	1,000	1	42000
Сургалтын хэрэглэгдэхүүн						
3	Саналын хайрцаг	ш	3	35,000	1	105000
Нийт дүн						231,000

--- оОо ---

.